



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/553

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4 дэх заалт, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 121 дугаар тогтоолын 4 дүгээр хэсгийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийн Жаргалан сумд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрээн нуурыг хамгаалах, нөхөн сэргээсэн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Д.Батмагнай	Байгаль орчны газрын дарга
Гишүүд:	Х.Цэнд-Аюуш	Байгаль орчин уур амьсгалын яам, Хяналт үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
	Х.Мягмаржав	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
	У.Батзаяа	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Хяналт шинжилгээний хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
	Э.Зол-Од	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)
	Б.Батбилэг	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилгын хяналтын улсын байцаагч
	М.Тулга	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн Зохицуулагч, (зөвшилцсөнөөр)

Н.Алтансүх	Байгаль орчны газрын мэргэжилтэн
Р.Мөнхбаяр	Жаргалан сумын Засаг дарга
М.Бямбадорж	Жаргалан сумын Бүрэн багийн Засаг дарга
Б.Болдбаатар	"Хидро инженеринг" ХХК-ний захирал
Д.Өлзийсайхан	"Усны эрчим" ХХК ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга: Б.Содмаа Байгаль орчны газрын Хүрээлэн
буй орчин байгалийн нөөцийн
хэлтсийн дарга, байгаль орчны
хяналтын улсын байцаагч

2.Эрээн нуурыг хамгаалах, нөхөн сэргээсэн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын гишүүн тус бүр батлагдсан зураг төсөв, ил далд ажлын акт, техникийн баримт бичгийн хамт газар дээр нь үзэж шалган дүгнэлт гаргах, мөн зураг төсөв, техникийн актыг 3 хувь үйлдэж Говь-Алтай аймгийн Төрийн архивын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, ашиглагч байгууллагад тус тус хүлээлгэж өгөхийг комиссын дарга (Д.Батмагнай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

